

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН  
2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭВЭР ТӨСВИЙН  
ТАЙЛАН

2015.01.15

Ховд

Тус хэлтэс нь 2014 оны 1-12 сарын дотор 2 сая 200 мянган үйл ажиллагаатай 55 ажил төлөвлөн түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч төлөвлөгдсөн 98 хувьтай биелж 1 ажил хагас хийгдсэн байна.

НЭГ.САНХҮҮ, ТӨСВИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН  
ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Орон нутгийн батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оны эхнээс үйл ажиллагаагаа бодитой төлөвлөн энэ хүрээнд цахим санхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх, санхүүгийн ажилтнуудыг чадавхижуулах, мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх, санхүүгийн сахилга, хариуцлагыг сайжруулан ажиллахад анхаарч санхүүгийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулж аймаг, орон нутгийн дэвшүүлсэн бодлого зорилтыг хэрэгжүүлэхэд гол ажлаа чиглүүлэн ажиллалаа.

Аймаг, нутгийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг байгууллага, эдийн засгийн ангиллаар төрийн сангийн сүлжээнд байршуулсан фискал програмд шивж, нэг хувийг цаасаар Сангийн яаманд хүргүүлэв. Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилал өөрчлөгдөн батлагдсан тул 2014 оны төсвийн сар, улирлын хуваарийг “fiscal” програмд дахин шивж улсын төсөвт нэгтгүүлэв.

2014 оны 1-12 сарын дотор 1 сая 200 мянган, тусгай зориулалтын шилжүүлэг, хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, Сангийн сайдын 2013 оны 303 дугаар тушаалыг үндэслэн 1 сая 200 мянган, Сангийн сайдын 2013 оны 303 дугаар тушаалыг үндэслэн 1 сая 200 мянган хуваарилж, “fiscal” програмд шивж оруулсан бөгөөд аймгийн Засаг даргын 2014 оны А/23 дугаар захирамжаар баталж, уг захирамжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар аймгийн Засаг даргын 1/554 дүгээр албан бичгээр сум, байгууллага, төрийн сан, Татварын хэлтэст хүргүүлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

2012 оны сонгуулийн үр дүнд ажлаас чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдад олгох тэтгэмжийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн олголоо.

Энэ онд 10 сумын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар заавар, зөвлөмж өгч ажилласан.

Эрүүл мэнд, боловсролын салбарын цалин хөлс, өрхийн эмнэлгийн зардал хүрэлцэхгүй байгаа тул харъяа төсөвт байгууллагуудаас бодит зардлын судалгааг авч нэгтгэн албан бичгээр холбогдох яамдад хүсэлт тавьсаны дүнд орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн байгууллагуудын төсвийн хүрэлцэхгүй байсан зарим зардал нэмэгдэж ирсэн юм.

Энэ онд төрийн албан хаагчийн цалин хөлсийг Засгийн газрын 2014 оны 75, 208, 332, 333 дугаар тогтоолын дагуу нэг хүний дундаж цалинг 3,75-10,8 хувиар нэмэгдүүлсэнийг салбар бүрээр нь төсөвт тусган бүрэн олголоо.

Àéì æéí Çàñàà ààðää, ñòì äùí Çàñàà даргаòàé ààéãóóëах áçòýýääýõççí í èèëççëýõ 2014 í í ù äýóýí д санхүү, төсвийн талаар 4 зорилт, 7 хөтөлбөр, 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган биелэлтийг оны эцэст дүгнэн Хяналт, үнэлгээний тасагт хүргүүлэв.

ОНХС-д эх үүсвэр нь батлагдсан “Цахим санхүү” хөтөлбөрийг боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн саналыг нь авч аймгийн ИТХ-д хүргүүлэн 2014 оны 6-р сарын 79 дүгээр тогтоолоор батлуулав. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргын 2014 оны 6 дугаар сарын А/337 дугаар захирамж гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд Sankhuu.kho.gov.mn цахим сайт хийж ажиллуулж байгаа бөгөөд мэдээллийн самбар ЗДТГ-ын 1 дүгээр давхарт байршуулан санхүү, төсвийн мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж байна.

Төсвийн шинэчлэл, Цахим санхүү хөтөлбөрийн хүрээнд аймгийн ЗДТГ-ын дэргэдэх 21 агентлаг, аймаг, сумын төсөвтэй харилцагч байгууллагуудын санхүүгийн ажилтан нийт 130 орчим хүнд “Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх, санхүүгийн зөрчлийг бууруулах”, “Төсвийг хөтөлбөр, арга хэмжээгээр төлөвлөх”, “Аж ахуйн нэгж, байгууллагуудын бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлангийн гаргалт, цахимаар тайланг илгээх ажлыг сайжруулах í ü” сэдэвт 4 өдрийн сургалт, семинар хийв.

Орон нутгийн төсвийн 2014 оны 1, 3 дугаар улирлын урьдчилсан гүйцэтгэл, цаашид хэрэгжүүлэх ажлын товч танилцуулгыг гарган жижиг боршрут ном болгон олшруулж ИТХ, аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын удирдлагуудад хүргүүлсэн бөгөөд санхүүгийн мэдээллийн самбар, цахим сайтаар тавьж иргэд олон нийтэд мэдээлэв.

Засгийн газрын “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2014 оны 147 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаар аймгийн Засаг даргын 2014 оны А/456 дугаар захирамж гарган сум, байгууллагуудад хүргүүлэн хэрэгжүүлэх явцад 2 удаа төрийн сангийн мэргэжилтэн нарт семинар, чиглэл өгч ажилласан.

Орон нутгийн төсвийн 2013 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлын хуваарилалтын талаар сум, байгууллагуудаас саналыг нь авч нэгтгэн боловсруулж аймгийн ИТХ-ын ҮI хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулан аймгийн Засаг даргын 2014 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 1/1774 дүгээр албан бичгээр сум, байгууллагуудад хүргүүлэв. Аймаг, сумдын ИТХ-аар батлагдсан давсан орлогын тодотголын нэгтгэлийг хийж Сангийн яаманд хүргүүлэв.

Орон нутгийн 2015 оны төсвийн төсөл, 2016-2017 оны төсвийн төсөөллийг боловсруулж ирүүлэх талаар Сангийн яамнаас ирсэн удирдамж, албан бичгийн дагуу сум, байгууллагуудад аймгийн Засаг даргын 7 дугаар сарын 10-ны өдрийн 1/1833 дугаар албан бичиг гарган хүргүүлэн үүний дагуу хүлээн авч нэгтгэн боловсруулж аймгийн ИТХТ-ийн хурал, төлөөлөгчдийн өдрөөр хэлэлцүүлэн саналыг нь тусган Сангийн яам, бусад холбогдох яамдад тушаав.

СЗХ-ноос ирүүлсэн удирдамжийн дагуу Бумбат Алтай брокерийн пүүсийн үйл ажиллагаанд газар дээр нь шалгалт хийж дүнг СЗХ-нд хүргүүлэв.

Цахим санхүү хөтөлбөрийн хүрээнд аймгийн ААН-ийн нягтлан бодогч нарт санхүүгийн тайлан гаргах, шивэх, санхүүгийн тайланд эдийн засгийн шинжилгээ хийх, ЖДААННБОУС-ийг хэрэглэх, НБББББ-ийг боловсруулах арга зүй сэдвээр 2 өдрийн сургалтыг зохион байгуулж 90 гаруй нягтлан бодогч хамрагдав.

МНББИ-ийн Ховд салбартай хамтран гишүүд, дэмжигчид, нягтлан бодогчид, эдийн засагчдын дунд “Санхүү, нягтлан бодох бүртгэлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашдын чиг хандлага” сэдвээр уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.

Аж ахуйн үзүүлэлт, аажим өсөхөд хүргэх 2013-ийн үндэсний төлөвлөгөөний дагуу 1297 аж ахуйн нэгжээс Е програмаар өргөтгөлийн зөвшөөрлийг баталгаажуулсан нь 96,6 хувийг, улирал бүр тайланг цахимаар 90-94 хувьтай тус тус авч дүнг Сангийн яаманд хүргүүлж байна.

Таблица 1.1 Аж ахуйн үзүүлэлт дагуу өсөх / буурах





Таблица 1.2 Аж ахуйн үзүүлэлт дагуу өсөх / буурах / тоогоор



Аж ахуйн үзүүлэлт 2013 онд 90,2 тэрбум төгрөг өсөхөд хүргэх, аажим үйлчилгээ үзүүлэн 89,4 тэрбум төгрөг өсөхөд хүргэх зорилгыг 0,7 тэрбум төгрөг өсөхөд хүргэх зорилгыг 1,2 тэрбум төгрөг буурсан байна.



Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтын 2013 оны баримтанд аудит хийлгэж, 2013 оны буцаан олголтыг 1738 иргэнд 620,9 сая төгрөг олгов.

Сумдын төрийн сангийн төлөөлөгч нарт 2 удаа төрийн сангийн програмын шинэчлэлт, тайлан, мэдээ гаргалт, ЗДТГ-ын нягтлан бодогч нартай хамтруулан төрийн сангийн дотоод хяналтын тухай ойлголт, санхүү, төсвийн талаар гарч буй заавар журмын өөрчлөлт, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол, түүнийг хэрэгжүүлэх, 2015-2017 оны төсвийн төсөл боловсруулах талаар заавар, зөвлөмж өгөв.

Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг хянаж, өр, авлагыг фрийбаланс програмд оруулан мэдээлж байна.

Аймаг, сумдын төрийн сангаас мөнгөн хөрөнгийн эргэлт, төсвийн хөрөнгийн эх үүсвэр, төсвийн зарцуулалтанд тавих хяналт сайжирч, санхүүжилт цаг хугацаандаа олгогдож, цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, иргэдэд олгох мөнгөн гүйлгээг шуурхай гүйцэтгэж байна.

Дээр дурдсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэний дүнд 2014 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэл дараах байдалтай гарахаар байгааг танилцуулъя.


### ГУРАВ.ТӨСВИЙН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ

Төсвийн гүйцэтгэлийн 12 дугаар сарын мэдээгээр орон нутгийн төсвийн орлогод 8571,3 сая төгрөг орж төлөвлөгөө 550,2 сая төгрөгөөр буюу 5,6 хувиар тасарсан байна. Үүнээс татварын орлогод 7578,3 сая төгрөг орж төлөвлөгөө 599,6 сая төгрөгөөр буюу 7,3 хувиар тасарч, татварын бус орлогод 843,2 сая төгрөг оруулж төлөвлөгөө 201,3 сая төгрөгөөр буюу 31,4 хувиар давсан байна.

Сангийн яамны орлогын хяналтын төлөвлөгөө 7,5 тэрбум төгрөг байсныг 8,5 тэрбум төгрөг төсөвт оруулж, төлөвлөгөөг 13,3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх суурь зарлагын 48,8 хувийг орон нутгийн төсвийн орлогоор бүрүүлсэн байна.

Гддд ёё 2.1. Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл /сая.төг/




Орон нутгийн төсвийн орлого тасарсан гол шалтгаан нь цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын албан татвар, түгээмэл тархацтай ашигт малтмалын орлого, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг өндөр төлөвлөн батлагдсан, энэ жил

хийгдсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт бүрэн орж ирээгүйгээс аж ахуйн нэгжүүд татвараа бүрэн төлөөгүйтэй холбоотой юм.

ОН-ийн төсвийн гүйцэтгэлийн 12 дугаар сарын мэдээгээр орон нутгийн төсвийн удирдлагыг хэрэгжүүлэхэд урсгал зарлага 16744.0 сая төгрөг хүрч, 1095.3 сая төгрөгөөр хэмнэгдэж байгаагийн ихэнх нь халамжийн сангийн төсвийн хэмнэлт эзэлж байна. Төсвийн өр 8,3 сая, авлага 12,1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс өр 98,8 сая, авлага 509,3 сая төгрөгөөр буурсан байна.


Гдэд өө 2.2. ОН-ийн төсвийн гүйцэтгэл / сая.төг/



Орон нутагт чиг үүрэг нь шилжиж ирсэн төсвийн байгууллагуудын төсвийн зарлага урьдчилсан байдлаар 35688,0 сая төгрөгт хүрч, 161,8 сая төгрөгийн хэмнэлттэй гарсан байна.


Төсвийн өр 84,3 сая, авлага 25,8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс өр 2,0 сая төгрөгөөр өсөж, авлага 50,8 сая төгрөгөөр буурсан байна. Өрийг салбараар авч үзвэл Эрүүл мэндийн салбарын сумдын эрүүл мэндийн төвүүд 30,2 сая, Боловсрол, соёлын салбарын байгууллагуудын өр 44,6, ГХБХБ-ын өр 4,0 сая, Хүүхэд, гэр бүл, хөгжлийн хэлтэс 5,5 сая төгрөг тус тус байна.

Гдэд өө 2.3. ОН-т чиг үүрэг нь шилжиж ирсэн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл /сая.төг/




Орон нутгийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийг зориулалтаар авч үзэхэд нийт төсвийн 28 хувийг удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд, 59 хувийг орон нутагт шилжиж ирсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд, 13 хувийг ОНХС буюу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан зарцуулсан байна.

Гддд ёё 2.4. ОН-ийн төсвийн бүтэц /зориулалт, хувиар/



Орон нутгийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтыг эдийн засгийн ангиллаар авч үзэхэд 39,4 хувийг ажиллах хүчний зардалд, 21,6 хувийг бараа, үйлчилгээний бусад зардалд, 19 хувийг татаас ба урсгал шилжүүлгийн зардалд зарцуулсан байна.

Гддд ёё 2.5. Орон нутгийн төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын зарцуулалтын бүтэц /сая.төг/



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 636,2 сая, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 11117,7 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 353,9 сая, нийт 12107,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээс орон нутгийн хөрөнгө оруулалт 636,2 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 224,9 сая, ОНХС-аас 8147,7 сая, нийт 9008,8 сая төгрөг олгосон нь төсөвлөснөөс санхүүжилт 3099,0 сая төгрөгөөр дутуу ирсэн байна.





ТАЙЛАН БИЧСЭН:  
СТСХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.ОТГОНХАНД

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:  
СТСХ-ИЙН ДАРГА П.АМГАЛАНБААТАР